



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/58

Хоад

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уяж хурдлуулсан хурдан хүлгүүд нь аймаг, сумын баяр наадамд олон удаа түрүү, айраг авч “Аймгийн алдарт уяач”-ийн болзол хангасан уяачдын үнэмлэх, малгай, малгайн залаа, энгэрийн тэмдэг, гарын бэлэгний зардлын төсвийг хавсралтаар батлаж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 4 280 000 төгрөг /дөрвөн сая хоёр зуун наян мянган/-ийг аймгийн Засаг даргын хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/58 Ch
02 00386

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 25-ны өдрийн
А/58 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН "АЛДАРТ УЯАЧ", "АЛТАН ХАРААЦАЙ" ЦОЛНЫ
ШАГНАЛЫН ТӨСӨВ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /мян.төг/
1	Үнэмлэх	40	5000	100.0
2	Малгай	40	24000	960.0
3	Залаа	40	13000	520.0
4	Гарын бэлэг	40	50000	2000.0
5	Дүн			4180.0
1	Өргөмжлөл	5	5000	25.0
2	Гарын бэлэг	5	15000	75.0
Дүн				100.0
Нийт дүн				4280.0

-оОо-